ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2026/001/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Улиастай сум
2026 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: bat-undraa@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Оюунсувд
Утас: 99076038
Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn
Аудитор: Т.Баасанжаргал
Утас: 92012266
Цахим хаяг: baasanjargalt@audit.gov.mn
Аудитор: Л.Гансүлд
Утас: 88161818
Цахим хаяг: gansuldl@audit.gov.mn

АГУУЛГА

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ 3-4

2. АУДИТ ХИЙСЭН ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН 5-7

2.1 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2.2 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ 7

3.1.1 Аудит хийсэн үндэслэл 7

3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ 7

3.1.3 Аудитын арга зүй 8

3.1.4 Материаллаг байдлын түвшин 8

3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж 8

3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн 8

3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР 9

3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан 9

3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан 9

3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан 9

3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан 9

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 9

4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ 9

4.2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 10

4.3 АВЛАГА 10

4.4 УРЬДЧИЛГАА 11

4.5 БАРАА МАТЕРИАЛ 11

4.6 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ 12

4.7 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 12

4.8 ҮНДСЭН ХӨРӨНГӨ 13

4.9 ӨР ТӨЛБӨР 14

Богино хугацаат Өр Төлбөр 14

Урт хугацаат Өр Төлбөр 14

4.10 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО 15

4.11 ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН БОЛОН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 16

Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит 17

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудит 17

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит 17

4.12 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА 18

4.13 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 18

4.14 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА 18

5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ 19

5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ 19

5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ 19

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчийн Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

Хүснэгт-1	*Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч*
Хүснэгт-2	*Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр*
Хүснэгт-3	*Авлагын үлдэгдэл*
Хүснэгт-4	*Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр*
Хүснэгт-5	*Бараа материал данс байгууллагын төрлөөр*
Хүснэгт-6	*Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр*
Хүснэгт-7	*Нийт өр төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр*
Хүснэгт-8	*Засгийн газрын хувь оролцоо*
Хүснэгт-9	*ТЕЗ-ийн харьяа ОНӨААН-үүдийн ашиг, алдагдал*
Хүснэгт-10	*Дүгнэлтийн хэлбэр*
Хүснэгт-11	*Өөрчлөлттэй дүгнэлт өгсөн байгууллагууд*
Хүснэгт-12	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас/Факс: 7046-3612
Цахим шуудан: zavkhan@audit.gov.mn

2026.04.20 № 267
танай -ны № -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Г.ӨНӨРБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Завхан аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Завхан аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд улсын төсвөөс 35,900.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 12,310.4 сая төгрөгийн санхүүжилт авч, татварын болон татварын бус орлогоос 35,699.7 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Аудитын гол асуудал

Завхан аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар төсвөөс хууль, журамд заагаагүй дэмжлэг, урамшуулал олгосон, бэлэг дурсгал, уралдаан тэмцээний шагналд 1,285.0 сая төгрөгийг зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн, аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сан, авто замын сан, орон нутгийн хөрөнгө оруулалт, сумдад эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга

8129050597

хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлээгүй, хөрөнгө оруулалтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан, харьяа орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд алдагдалтай ажиллаж байгаад дүн шинжилгээ хийж, санхүүгийн үр ашгийг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, нийт 1,552.3 сая төгрөгийн зөрчил байна.

Бусад асуудлын хэсэг

Завхан аймгийн Засаг даргын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд 4 бүлгийн хүрээнд 170 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 50 дугаар тогтоолоор 93.4 хувийн биелэлттэй буюу **"Үр дүнтэй"** гэж дүгнэжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 11,734.0 сая төгрөгийн зөрчил илэрч, 14 байгууллага хязгаарлалттай, 3 байгууллага сөрөг дүгнэлт авсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.
Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭГЧ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31 */мянган төгрөгөөр/*

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		26,596,545.80	29,887,420.10
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	17,585,611.80	18,997,182.60
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	6,251,660.00	7,477,008.10
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	3,003.90	3,591.90
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	2,756,270.10	3,409,637.50
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		57,603,313.10	75,578,330.70
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	57,603,313.10	75,578,330.70
8	1.2.2.02 Биет хөрөнгө		53,399,135.70	71,225,833.00
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	4,204,177.30	4,352,497.60
10	**1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2**		**84,199,858.90**	**105,465,750.80**
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,081,760.00	3,600,680.00
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		777,314.40	2,296,234.40
13	2.1.1.03 Өглөг		623,134.50	2,140,959.70
14	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	18а, 18б	154,179.90	155,274.70
15	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,304,445.60	1,304,445.60
16	2.1.2.02 Урт хугацаат зээл	20а, 20б	1,304,445.60	1,304,445.60
17	**2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**		**82,118,098.90**	**101,865,070.80**
18	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		82,118,098.90	101,865,070.80
19	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		17,805,346.60	17,458,268.20
20	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/		6,594,152.10	8,390,317.40
21	2.2.1.06 Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/		202,588.00	202,588.00
22	2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ		228,205.10	228,205.10
23	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		51,074,260.00	68,432,553.70
24	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		6,213,547.10	7,153,138.40
25	**2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5**		**84,199,858.90**	**105,465,750.80**

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31 */мянган төгрөгөөр/*

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	**1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН**		**108,574,324.9**	**117,631,091.3**
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		27,412,196.4	31,849,522.9
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		22,264,016.2	24,777,884
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		22,035,694.4	23,540,908.1
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-1,208,652.6	-1,512,749.1
6	1.1.1.03.1.03 Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		984.2	0
7	1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар		1,435,990.1	2,749,725.1
8	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		2,363,018.9	2,726,088.8
9	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		2,785,161.4	4,345,550.1
10	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	78,289,684.5	85,781,568.4
11	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	7,525,914
12	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,872,444	0.0
13	**1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**2а, 2б**	**67,576,575.7**	**76,486,848**
14	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		67,576,575.7	74,162,105.8

15	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		65,003,336	72,014,585.4
16	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		22,847,307.2	27,344,625.2
17	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,880,224.6	3,570,638.6
18	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		15,586,415	18,020,056.6
19	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		2,072,305	2,040,980.4
20	1.1.2.01.1.05 Норматив зардал		194,338.6	279,718.5
21	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		771,872.2	922,318.3
22	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		526,960	495,655.3
23	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		5,442,573	5,876,526.7
24	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		14,681,340.5	13,464,065.8
25	1.1.2.01.3 ТАТААС		0	30,000
26	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,573,239.7	2,117,520.4
27	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	2,324,742.2
28	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		40,997,749.2	41,144,243.3
29	1.2.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	16,749.5
30	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		24,659,267.7	22,407,631.2
31	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		-24,659,267.7	-22,390,881.7
32	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		16,338,481.5	18,753,361.6

2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31 */мянган төгрөгөөр/*

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,300,683.00	65,300,683.00
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	478,934.30	478,934.30
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	65,779,617.30	65,779,617.30
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	16,335,882.10	16,335,882.10
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл	82,115,499.40	82,115,499.40
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	82,115,499.40	82,115,499.40
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	88,066.60	88,066.60
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	82,203,566.00	82,203,566.00
9	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	142,575.20	142,575.20
10	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(646.10)	(646.10)
11	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	766,214.10	766,214.10
12	1.7 Тайлант үеийн үр дүн	18,753,361.60	18,753,361.60
13	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	101,865,070.80	101,865,070.80

2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31 */мянган төгрөгөөр/*

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	**1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН**	**95,182,937.7**	**100,157,084.5**
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	27,412,196.4	31,849,522.9
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	22,264,016.2	24,777,884
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,208,652.6	-1,512,749.1
5	1.1.1.1.03.1.03 Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	984.2	0.0
6	1.1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар	1,435,990.1	2,749,725.1
7	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	2,363,018.9	2,726,088.8
8	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	2,785,161.4	4,345,550.1
9	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	526,931.7	1,406,241.4
10	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	1,132,401.9	1,535,485.4
11	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,125,827.7	1,375,885.1
12	1.1.1.1.03.8.04 Бусад татвар	0.0	27,938.1
13	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,863,103.4	68,307,561.6
14	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	13,185,925.5	12,569,245.2
15	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	7,527,286.8
16	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	51,677,177.9	48,211,029.6
17	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,907,637.9	0.0
18	**1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**64,098,271.1**	**68,769,301.6**
19	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	64,098,271.1	68,769,301.6
20	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,548,288.8	67,802,821.3
21	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,405,871.3	28,106,624.6
22	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,232,383.6	3,523,842.6
23	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,234,825.9	18,738,605.7
24	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	2,239,521.4	1,915,678.9
25	1.1.1.2.01.1.05 Норматив зардал	189,369.5	258,875.9
26	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	764,841.4	865,207.1
27	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	505,754.9	483,110.5
28	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,020,658.1	5,871,379.1
29	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	9,955,062.7	8,039,496.9
30	1.1.1.2.01.3 ТАТААС	0	30,000
31	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,549,982.3	936,480.3
32	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	31,084,666.5	31,387,782.9
33	1.1.2.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	725	6,253.2
34	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	27,021,414.2	27,919,940.1
35	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,021,414.2	27,919,940.1
36	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	27,021,414.2	27,919,940.1
37	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-27,020,689.2	-27,913,686.8
38	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,246,346.1	1,941,825.7
39	1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	94,611	120,699.6
40	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,340,957.1	-2,062,525.3
41	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,723,020.2	1,411,570.7
42	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,862,591.6	17,585,611.8
43	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,585,611.8	18,997,182.6

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

3.1.1 Аудит хийсэн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Завхан аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС болон бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар дүгнэлт гаргахад аудитын зорилт чиглэсэн.

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгууд Аудитын Олон Улсын стандарт, Төрийн аудит MNS 6817-4:2020 Санхүүгийн аудитын тулгуур зарчимд заасны дагуу аудитын горим, сорилыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай хууль болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төрийн сан, төсөл хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

3.1.3 Аудитын арга зүй

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим хэрэгжүүлж гүйцэтгэлээ.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл, мөн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэл зэрэг асуудлуудыг авч үзсэн.

3.1.4 Материаллаг байдлын түвшин

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө 105,465.7 сая төгрөгөөс 1.5 хувь буюу 1,582.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 1,186.5 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь заалтын дагуу Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, хуулийн хугацаанд 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 08/352 тоот албан бичгээр Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Үүнд:

- *Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөв захирагч хоорондын ажил гүйлгээний давхардсан 174,41.8 сая төгрөгийг санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд цэвэрлэх бичилт хийсэн байна.*

- *Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр тайлагнасан байна.*

3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлжээ.

3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны төрийн сангийн удирдлагын "finperform" цахим системээр нэгтгэн гаргасан бөгөөд дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

А. Үндсэн тайлан	Б.Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В: Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	НББ-ийн бодлого, 1-28 тодруулгууд
ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	1а, 1б, 2а, 2б тодруулга
ТЕЗ-ийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	

3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр, төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 21,265.8 сая төгрөгөөр буюу 25.2 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Эзлэх хувь
Б	1	2	3=2-1	
Эргэлтийн хөрөнгө	26,596.6	29,887.4	3,290.8	28.3%
Эргэлтийн бус хөрөнгө	57,603.3	75,578.3	17,975.0	71.7%
Нийт хөрөнгө	**84,199.9**	**105,465.7**	**21,265.8**	**100%**
Нийт өр төлбөр	2,081.8	3,600.7	1,518.9	3.4%
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	82,118.1	101,865.0	19,746.9	96.6%
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**84,199.9**	**105,465.7**	**21,265.8**	**100%**

Эх сурвалж: Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо зэрэг данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Нийт хөрөнгө өмнөх оноос 21,264.2 сая төгрөгөөр өсөхөд төсвийн хөрөнгөөр 2,524.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 19,760.1 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, үндсэн хөрөнгө өссөн нь голлох нөлөө үзүүлжээ.

3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 18,753.4 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй байна.

Төсөвт байгууллага 15,904.1 сая төгрөг, төрийн сангийн үйл ажиллагааны үр дүн 2,211.3 сая төгрөг, төсөл сангийн үйл ажиллагааны үр дүн 714.3 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны үр дүн 78.0 сая төгрөгийн алдагдалтай байна.

3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Аймгийн Засаг даргын 2025 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо өмнөх оноос 19,747.0 сая төгрөгөөр, тайлант үеийн үр дүн 2,414.9 сая төгрөгөөр өссөн байна.

3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Аймгийн Засаг даргын 2025 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд мөнгөн орлого 100,157.1 сая төгрөг, зарлага 68,769.3 сая төгрөг, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 31,387.8 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй байна.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 18,997.2 сая төгрөг болж, өмнөх оноос 1.411.6 сая төгрөгөөр өссөн байна. Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 18,783.3 сая төгрөг буюу 98.9 хувь нь төрийн сангийн харилцах дансанд, 210.3 сая төгрөг буюу 1 хувь нь арилжааны банканд байршиж байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Кассад байгаа бэлэн мөнгө	10.8	15.6	4.8	0.08%
Банканд байгаа бэлэн мөнгө	17,574.8	18,981.6	1,406.8	99.92%
Төрийн сангийн харилцах	17,517.5	18,783.3	1,265.8	98.96%
Арилжааны банк дахь харилцах	55.8	198.3	142.5	1.04%
Нэмэлт санхүүжилт харилцах	1.5	-	-1.5	-
Дүн	**17,585.6**	**18,997.2**	**1,411.6**	**100%**
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	17.3	17.8	0.5	0.09%
Төсөл/сан	9,364.3	8,411.5	(952.8)	44.3%
Төрийн сан	8146.3	10,357.6	2,211.3	54.5%
ОНӨААН	57.7	210.3	152.6	1.1%
Дүн	**17,585.6**	**18,997.2**	**1,411.6**	**100%**

Эх сурвалж: Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд тайлант онд хийгдэж дуусаагүй хөрөнгө оруулалтуудын үлдэгдэл санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээ хийгдээгүй, санхүүжилтийн эрх нээгдээгүйгээс зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгоогүй, зарим сумдад нөхөн сэргээлтийн данс шинээр нээгдэж орлого төвлөрүүлсэн, Нөмрөг, Завханмандал, Сонгино, Яруу, Ургамал сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн авлага барагдаж үлдэгдэл өссөн болон Их-уул, Отгон, Ургамал, Асгат, Завханмандал сумдын татварын орлого давж биелсэн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 0.09 хувийг төсөвт байгууллага, 44.3 хувийг төсөл сан, 54.5 хувийг төрийн сан, 1.1 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх гэх үндэслэлээр төрийн албан хаагчдад орон сууцны дэмжлэг,, уралдаан тэмцээний шагнал, урамшуулал, хоол хүнсний материал, бэлэг дурсгалд 1,285.0 сая төгрөг зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн, их засварын зардлаас 50.0 сая төгрөгийг зориулалт бус төсөл арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан, мөн барьцаа хөрөнгийн дансны үлдэгдлээс 217.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар хувь хүний дансаар мөнгө дамжуулан зарцуулж, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй, зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй, Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан, орон тооны бүтцэд батлагдаагүй ажилд хавсарсан нэмэгдэл олгосон, цалин урамшуулал илүү тооцож олгосон, аливаа хуулийн этгээдүүдтэй гэрээ байгуулан ажил

гүйцэтгүүлэхдээ үйл ажиллагааны чиглэлийг харгалзан үздэггүй, ажил гүйцэтгэсэн тайлан, анхан шатны баримт хангалтгүй, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын урьдчилгаа санхүүжилт олгосон болов гэрээний хугацаанд бүрэн хийгдээгүй, хуульд зааснаас бусад хэлбэрээр тэтгэмж, урамшуулал, дэмжлэг олгосон, багийн өдөрлөг, урлаг, спортын тэмцээн зохион байгуулж, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн зэрэг зөрчил илэрсэн байна.

4.2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат хөрөнгө оруулалттай холбоотой бүртгэл байхгүй байна.

4.3 АВЛАГА

Авлага дансны эцсийн үлдэгдэл 7,477.0 сая төгрөг болж, өмнөх оноос 1,225.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь 22 сум хоршоо хөгжүүлэх сангаас 1,941.8 сая төгрөгийн зээл олгож авлага үүсгэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Нийт авлагын үлдэгдлийн 6.9 хувийг төсөвт байгууллага, 87.4 хувийг төсөл сан, 2.7 хувийг төрийн сан, 3 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага тус тус эзэлж байна.

Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл */сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбоотой авлага	23.4	15.7	-7.65	21.0%
Төлбөртэй үйлчилгээний авлага	19.5	389.5	-30.0	5.2%
Татаас, санхүүжилтийн авлага	-	22.2	22.2	0.3%
Данс авлага /ТӨҮГ/	92.3	168.9	76.5	2.6%
Татвар НДШ авлага /ТӨҮГ/	0.7	0.6	-0.0	0.0%
Байгууллагаас авах авлага	856.1	1,418.8	562.6	18.9%
Хувь хүмүүсээс авах авлага	4,859.70	5,461.3	601.5	73.0%
Дүн	**6,251.70**	**7,477.0**	**1,225.3**	**119.6%**
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	269.8	518.2	248.4	6.9%
Төсөл/сан	5.660.8	6,535.9	875.1	87.4%
Төрийн сан	199.2	199.3	0.1	2.7%
ОНӨААН	121.9	223.6	101.7	3%
Дүн	**6,251.70**	**7,477.0**	**1,225.3**	**119.6%**

Эх сурвалж: Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн нь төсөвт байгууллагуудын авлага 248.4 сая төгрөгөөр, төсөл сангийн авлага 875.1 сая төгрөгөөр, төрийн сангийн авлага 0.1 сая төгрөгөөр, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн авлага 101.7 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын хүрээнд тайлант онд үүссэн авлагыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, авлагыг дутуу болон зөрүүтэй тайлагнасан, хэмнэгдсэн зардлыг НДШ-д шилжүүлж авлага үүсгэсэн, он дамжсан авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хугацаа хэтэрсэн авлагыг шүүхийн байгууллагад шилжүүлээгүй, шүүхийн шийдвэрийн хугацаа дуусан байхад шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлэн барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн байна.

4.4 УРЬДЧИЛГАА

Урьдчилж гаргасан зардал дансны үлдэгдэл 3.6 сая төгрөг болж, 0.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр */сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Урьдчилж гарсан зардал	3.0	3.6	0.6	100%
Дүн	**3.0**	**3.6**	**0.6**	**100%**

Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	-	-	-	
ОНӨААН	3.0	3.6	0.6	100%
Дүн	**3.0**	**3.6**	**0.6**	**100%**

Эх сурвалж: Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд бүртгэлтэй 3.6 сая төгрөгийн үлдэгдлээс 2.0 сая төгрөг нь Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний албаны 2022 онд гэрээгээр хөрсний гүний бохирдол хэмжих ажил гүйцэтгүүлэхээр, 1.6 сая төгрөг нь "Тосон очирт хайрхан" ОНӨААН-ийн цалингийн урьдчилгаатай холбоотой урьдчилж гарсан зардал байна.

4.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 3,409.6 сая төгрөг болж, өмнөх оноос 653.3 сая төгрөгөөр өссөн байна. Нийт бараа материалын үлдэгдлийн 84.3 хувийг төсөвт байгууллага, 15.7 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн бараа материал тус тус эзэлж байна.

Хүснэгт №5. Бараа материал данс байгууллагын төрлөөр */сая төгрөгөөр*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)	Хувь
Түүхий эд материал	**145.3**	**215.9**	**70.5**	6%
Тусгай зориулалттай материал	142.0	164.5	22.5	5%
Эм боох материал	2.4	50.5	48.1	1%
Бэлэн бүтээгдэхүүн	0.9	0.9	-	0%
Хангамжийн материал	**2,534.5**	**3,084.3**	**549.8**	90%
Бичиг хэргийн материал	69.1	77.8	8.7	2%
Аж ахуйн материал	1,179.0	1,148.9	(30.1)	34%
Сэлбэг хэрэгсэл	58.0	55.9	(2.1)	2%
Түлш, шатах тослох материал	77.5	33.3	(44.2)	1%
Барилгын засварын материал	50.0	45.1	(4.9)	1%
Хүнсний материал	0.1	-	(0.1)	0%
Бусад хангамжийн материал	1,100.9	1,723.4	622.5	51%
Мал амьтад	**76.4**	**109.5**	**33.0**	3%
Дүн	**2,756.3**	**3,409.6**	**653.3**	**124%**
Байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	2,370.2	2,948.9	578.7	84.3%
ОНӨААН	386.1	460.7	74.6	15.7%
Дүн	**2,756.3**	**3,409.6**	**653.3**	**124%**

Эх сурвалж: Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал 653.3 сая төгрөгөөр өссөн нь түүхий эд материал 70.5 сая төгрөгөөр, хангамжийн материал 549.8 сая төгрөгөөр, мал амьтад 33.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөөг үзүүлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 3,531.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандив тусламжаар 333.8 сая төгрөгийн, хөрөнгө оруулалтаар 446.5 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, балансаас баланст 80.3 сая төгрөгийн материал шилжүүлэн авч нийт 4,391.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 3,430.0 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулан, 72.2 сая төгрөгийн бараа материалыг балансаас баланст шилжүүлж, 234.7 сая төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Аудитын илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын хүрээнд худалдан авсан бараа материалыг тодруулга тайлангаар дамжуулаагүй, шууд зардлаар тайлагнасан, бараа материалыг зөв ангилж бүртгээгүй, бараа материалыг нэр төрөл, тоо ширхгээр бүртгээгүй бөөн дүнгээр орлого авсан, хөрөнгө оруулалтаар ирсэн бараа материал болон ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн өвс тэжээлийг данс бүртгэлд тусгаагүй, бараа материалын жилийн эцсийн тооллого хийгээгүй, эргэлтийн хөрөнгийг карталж ашиглалтын бүртгэл хөтлөөгүй зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн байна.

4.5 НӨӨЦИЙН БАРАА

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нөөцийн бараа данстай холбоотой бүртгэл байхгүй байна.

4.6 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бусад эргэлтийн хөрөнгө данстай холбоотой бүртгэл байхгүй байна.

4.7 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт данстай холбоотой бүртгэл байхгүй байна.

4.8 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 75,578.3 сая төгрөг болж, өмнөх оноос 17,975.0 сая төгрөгөөр өссөн байна. Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 87 хувийг төсөвт байгууллага, 13 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө тус тус эзэлж байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр */сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Биет хөрөнгө	**53,399.0**	**71,225.8**	**17,826.8**	**94%**
Барилга, байгууламж, орон сууц	28,997.6	36,184.7	7,187.1	48%
Авто-тээврийн хэрэгсэл	8,036.4	10,119.8	2,083.4	13%
Машин тоног төхөөрөмж(компьютер)	9,160.1	10,895.2	1,735.1	14%
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,091.7	1,439.1	347.4	2%
Зам гүүрний байгууламж	22.8	5,302.1	5,279.3	7%
Түүх соёл, музейн дурсгалт зүйл	3.7	3.7	0.0	0%
Бусад үндсэн хөрөнгө	6,056.4	7,250.9	1,194.5	10%
Ном	30.3	30.3	0.0	0%
Биет бус хөрөнгө	**4,204.3**	**4,352.5**	**148.2**	**6%**
Программ хангамж	69.6	53.9	(15.7)	0%
Газар		1.1	1.1	0%
Бусад биет бус хөрөнгө	4,134.7	4,297.5	162.8	6%
Дүн	**57,603.3**	**75,578.3**	**17,975.0**	**131%**
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	49,723.2	65,663.4	15,940.2	87%
ОНӨААН	7,880.1	9,914.9	2,034.8	13%
Дүн	**57,603.3**	**75,578.3**	**17,975.0**	**131%**

Эх сурвалж: Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны өөрчлөлт нь төсвийн хөрөнгөөр 2,524.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 19,760.1 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан, 1,801.1 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан, 577.0 сая төгрөгийн хөрөнгө дахин үнэлж бүртгэсэн, эрх бүхий байгууллагын шийдвэрээр 197.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдсан, 1,895.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан, 975.4 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн, аудитын шийдвэрээр 361.8 сая төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлсэн, мөн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ч цаашид ашиглах боломжтой хөрөнгүүдэд үнэ тогтоож, дахин үнэлгээний хорогдол 736.0 сая төгрөгөөр хасагдсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Орон нутгийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн хөрөнгө болон сумдад эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй 476.8 сая төгрөгийн болон аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгийг журам зөрчсөн төсөл арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд хийгдээгүй, бүрэн дуусаагүй 3.891.2 сая төгрөгийн зөрчил давтагдан гарч байгаад хяналт хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийг

данс бүртгэлд тусгаагүй, үндсэн хөрөнгийг зөв ангилж бүртгээгүй, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг зөв тодорхойлоогүй, элэгдэл дутуу тооцоолсон, жилийн эцсийн тооллого хийгээгүй, тооцоо бодож баримтжуулаагүй, хөрөнгийн ашиглалтын карт хөтлөөгүй, үлдэх өртөггүй хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт болон аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээг хүлээн авах комисст аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтнүүдээс оруулж, бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх боломжоор хангаж ажиллах шаардлагатай байна.

4.9 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 3,600.7 сая төгрөг болж, өмнөх оноос 1,518.9 сая төгрөгөөр өссөн байна. Нийт өр төлбөрийн үлдэгдлийн 48.3 хувийг төсөвт байгууллага, 51.7 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн өглөг тус тус эзэлж байна.

Хүснэгт №7. Нийт өр төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Хувь
Богино хугацаат өр төлбөр	**777.3**	**2,296.2**	**1,518.9**	**63.8%**
Ажилчидтай холбогдсон өглөг	15.4	118.3	102.9	**3.3%**
Бараа үйлчилгээний зардлын өглөг	42.8	192.4	149.6	**5.3%**
Хувь хүмүүст төлөх өглөг	20.2	181.1	160.8	**5%**
Байгууллагад төлөх өглөг	310.5	1,366.7	1,056.1	**38%**
Татварын өглөг /ТӨҮГ/	160.3	182.4	22.1	**5%**
НДШ өглөг /ТӨҮГ/	3.3	4	0.6	**0.1%**
Данс өглөг /ТӨҮГ/	70.7	96.1	25.3	**2.7%**
Урьдчилж орсон орлого	154.2	155.3	1.0	4.3%
Бусад урьдчилж орсон орлого	154.2	155.3	1.0	**4.3%**
Урт хугацаат өр төлбөр	**1,304.5**	**1,304.5**	**-**	**36.2%**
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	1,304.5	1,304.5	-	**36.2%**
Дүн	**2,081.8**	**3,600.7**	**1,518.9**	**100%**
Байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	388.9	1,739.6	1,350.7	48.3%
ОНӨААН	1,692.9	1,861.1	168.2	51.7%
Дүн	**2,081.8**	**3,600.7**	**1,518.9**	**100%**
Богино хугацаат өр төлбөр				
Төсөвт байгууллага	388.9	1,739.6	1,350.7	75.8%
ОНӨААН	388.4	556.6	168.2	24.2%
Дүн	**777.3**	**2,296.2**	**1,518.9**	**100%**
Урт хугацаат өр төлбөр				
Төсөвт байгууллага	-			
ОНӨААН	1,304.5	1,304.5	-	100%
Дүн	1,304.5	1,304.5	-	100%

Эх сурвалж: Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр: Богино хугацаат өр төлбөрийн 68.6 хувь буюу 1,575.2 сая төгрөгийг төсөвт байгууллагын өглөг эзэлж, үүнээс улсын төсөвт байгууллагуудын халаалтын зардлын 282.1 сая төгрөгийн, аймгийн Засаг дарга дансанд 90.1 аймаг хөгжүүлэх сангийн 214.6 Тосонцэнгэл сумын ОНХС-ийн 516.3 сая төгрөгийн, Цагаанхайрхан сумын ОНХС-ийн 88.0 сая төгрөгийн, Улиастай сумын ОНХС-ийн 68.4 сая төгрөгийн, Яруу сумын ОНХС-ийн 35.0 сая төгрөгийн өглөг голлох нөлөөг үзүүлж байна.

Нийт богино хугацаат өр төлбөрийн 31.4 хувь буюу 721.0 сая төгрөгийг орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн өглөг эзэлж, "Амь-Ус" ХХК 30.8 сая төгрөг, "Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв" ОНӨТҮГ 42.7 сая төгрөг, Эрдэнэхайрхан хөгжил 2.5 сая төгрөг, "Очир-Илч" ХХК 102.8 сая төгрөг, Улиастай сумын хот тохижилт үйлчилгээний алба

166.9 сая төгрөг, Тосонцэнгэл сумын тохижилт үйлчилгээний алба 9.4 сая төгрөг, "Тосон очирт хайрхан" ОНӨААН 213.1 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Улиастай сумын хот тохижилт үйлчилгээний алба, "Очир-Илч" ХХК ОНӨААН, "Тосон очирт хайрхан" ОНӨААН-ийн өглөг нь орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн өглөгийн 84.9 хувийг эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөр: Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 1,304.5 сая төгрөг бөгөөд тайлант онд нэмэгдээгүй байна. Тус өглөг нь "Амь-Ус" ХХК-ийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн Азийн хөгжлийн банкнаас нийтийн ахуй үйлчилгээг дэмжих чиглэлээр авсан урт хугацаат зээл бөгөөд 20 гаруй жилийн насжилттай өглөг байна. Сангийн яамнаас 2022, 2023 онуудад "Амь-Ус" ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 1,304.5 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрт орон нутгийн санхүүгийн дэмжлэгээс 179.4 сая төгрөгийг суутгасныг тус аж ахуйн нэгжээс авахаар авлага үүсгэсэн байна. "Амь-Ус" ХХК-ийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгж нь тус урт хугацаат өр төлбөрийг төлөх боломжгүй гэх тайлбарыг өгсөн.

Аудитын илрүүлэлт:
ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар өр төлбөртэй холбоотой зөрчил илрээгүй байна. Харин харьяа байгууллагуудын хүрээнд тайлант онд үүссэн өр төлбөрийг зөрүүтэй болон дутуу тайлагнасан, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн байна.

4.10 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 101,865.0 сая төгрөг болж, өмнөх оноос 19,746.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8. Засгийн газрын хувь оролцоо */сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	**17,805.3**	**17,458.3**	**-347.0**	**17.2%**
Өмч /ТӨҮГ/	6,594.2	8,390.3	1,796.1	8.2%
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	202.6	202.6	-	0.2%
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	228.2	228.2	-	0.2%
Хуримтлагдсан үр дүн	**51,074.2**	**68,432.5**	**17,358.4**	**67.2%**
Өмнөх үеийн үр дүн	34,735.7	49,679.2	14,943.5	48.8%
Тайлант үеийн үр дүн	16,338.5	18,753.4	2,414.9	18.4%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	**6,213.5**	**7,153.1**	**939.6**	**7%**
Дүн	**82,118.1**	**101,865.0**	**19,746.9**	100%

Эх сурвалж: Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 19,746.9 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн өмч болон хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү нэмэгдсэн, тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Хүснэгт №9. ТЕЗ-ийн харьяа ОНӨААН-үүдийн ашиг, алдагдал */сая төгрөгөөр/*

№	ОНӨААН-ийн нэр	Орлого	Зарлага	2025 оны үр дүн	Өмнөх үеийн үр дүн	Хуримтлагдсан үр дүн
1	Тосон очирт хайрхан	1,074.1	1,360.7	-286.6	-1,750.6	(2,037.2)
2	Эрдэнэ хайрхан хөгжил	315.6	321.5	-5.9	31.4	25.5
3	"Очир-Илч" ОНӨААН	451.3	507.8	-56.4	-1,242.7	-1,299.1
4	Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв	1,015.1	10,618	-29.9	-19.2	-49.1
5	Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба	217.0	480.9	-263.9	-116.3	-381.2
6	"Амь-Ус" ХХК	2,129.1	1,958.4	170.7	-848.9	-673.4
7	Дөрвөн-Оноо өрхийн ЭМТ	631	659.2	-28.2	159.8	131.5
8	Биндэргарав өрхийн ЭМТ	546.7	601.3	-54.6	153.1	98.5
9	Тосонцэнгэл сумын "Мөнхийн алба" өрхийн ЭМТ	647.9	612.1	35.8	153.5	189.2

10	Завхан аймгийн ЗДТГ-ын дэргэдэх теле камерын хяналтын дэд төв	66.9	64.8	2.1	-	2.1
11	Улиастай сумын тохижилт үйлчилгээний алба	2,866.2	2,035.4	439.0	1,881.3	2,320.3
Дүн		**7,094.7**	**17,184.7**	**-77.9**	**-3,479.9**	**-3,990.0**

ТЕЗ-ийн харьяа 11 орон нутгийн өмчит хуулийн этгээдээс 2025 онд 7 ОНӨААН 725.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үүнд: "Тосон очирт хайрхан" ОНӨААН-ийн алдагдал 39.5 хувийг, "Эрдэнэ хайрхан хөгжил" ОНӨААН-ийн алдагдал 0.8 хувийг, "Очир илч" ОНӨААН-ийн алдагдал 7.8 хувийг, Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний албаны алдагдал 36.4 хувийг, "Биндэргарав" өрхийн ЭМТ-ийн алдагдал 7.5 хувийг, "Дөрвөн-Оноо" өрхийн ЭМТ-ийн алдагдал 3.9 хувийг, Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төвийн алдагдал 4.1 хувийг тус тус эзэлж байна.

ТЕЗ-ийн харьяа орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 2025 онд алдагдалтай ажилласан шалтгааныг дурдвал:

- *"Тосон очирт хайрхан" ОНӨААН алдагдалтай ажилласны гол шалтгаан нь цэвэр ус үйлдвэрлэлийн зардал, нүүрсний үнэ өссөн, хангамжийн бараа материалын зардал өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.*
- *"Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв" ОНӨТҮГ-ийн алдагдалтай ажилласан шалтгаан нь ашиглалтын зардлын тариф өссөн, бараа материалын үнэ өссөнтэй холбоотой байна.*
- *"Эрдэнэхайрхан хөгжил" ОНӨААН-ийн алдагдалтай ажилласан шалтгаан нь гэр хорооллын халаалтын шугамын зураг төслийг 30.0 сая төгрөгөөр хийлгэсэнтэй холбоотой байна.*
- *"Очир-Илч" ХХК ОНӨААН-ийн өглөг нэмэгдэж, алдагдалтай ажилласан шалтгаан нь халаалт болон эрчим хүчний тариф нэмэгдсэн, түрээсийн орлогоор тогтмол зардал нөхөж хүрэлцдэггүйтэй холбоотой байна.*
- *Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний албаны алдагдалтай ажилласан шалтгаан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нөлөөлсөн байна.*

Аудитын илрүүлэлт:
Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд алдагдалтай ажиллаж байгаад дүн шинжилгээ хийж, санхүүгийн үр ашгийг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

4.11 ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ:

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 24 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, 108 төсвийн байгууллага, 11 орон нутгийн өмчит хуулийн этгээд нийт 143 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Аудитад хамрагдсан 143 санхүүгийн тайлангаас төсөв, санхүүжилт, хамрах хүрээ, аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөө харьцангуй багатай 96 санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулж, 47 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргалаа. Үүнд:

Хүснэгт №10. Дүгнэлтийн хэлбэр

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлттгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
А	1	2	3	4	5	7	8	9	10

1	Төсвийн шууд захирагч	108	15	93		10	3	2	
2	ОНӨААН	11	8	3		7	1		
3	Төсвийн төвлөрүүлэн захирагч	24	24			13	10	1	
НИЙТ		**143**	**47**	**96**		**30**	**14**	**3**	

Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит:

Аудитаар нийт 14,734.0 сая төгрөгийн 223 зөрчил илэрснээс 4,965.2 сая төгрөгийн зөрчилд 48 заалт зөвлөмж, 6,717.5 сая төгрөгийн зөрчилд 136 албан шаардлага өгч, 51.2 сая төгрөгийн зөрчилд 36 төлбөрийн акт тогтоож, санхүүгийн тайлангийн аудитаар "Сөрөг" дүгнэлт авсан 3 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн байна.

Хүснэгт №11 Өөрчлөлттэй дүгнэлт өгсөн байгууллагууд

№	Байгууллагын нэр	Өгсөн дүгнэлт	№	Байгууллагын нэр	Өгсөн дүгнэлт
1	Аймгийн ИТХ	Хязгаарлалттай	10	Цэцэн-Уул сумын Засаг дарга	Хязгаарлалттай
2	Дөрвөлжин сумын ЗДТГ	Хязгаарлалттай	11	Яруу сумын Засаг дарга	Хязгаарлалттай
3	Түдэвтэй сумын ЗДТГ	Хязгаарлалттай	12	Цагаанхайрхан сумын Засаг дарга	Хязгаарлалттай
4	АЗДТГ-ын дэргэдэх теле камерын төв ОНӨААН	Хязгаарлалттай	13	Тосонцэнгэл сумын Засаг дарга	Хязгаарлалттай
5	Баянхайрхан сумын Засаг дарга	Хязгаарлалттай	14	Сонгино сумын Засаг дарга	Хязгаарлалттай
6	Нөмрөг сумын Засаг дарга	Хязгаарлалттай	15	Отгон сумын Засаг дарга	Сөрөг
7	Дөрвөлжин сумын Засаг дарга	Хязгаарлалттай	16	Улиастай сумын ЗДТГ	Сөрөг
8	Улиастай сумын Засаг дарга	Хязгаарлалттай	17	Яруу сумын ЗДТГ	Сөрөг
9	Эрдэнэхайрхан сумын Засаг дарга	Хязгаарлалттай			

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудит:

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 9,569.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4,606.3 сая төгрөгийн зөрчилд 33 заалт зөвлөмж, 4,916.8 сая төгрөгийн зөрчилд 119 албан шаардлага өгч, 45.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, санхүүгийн аудитаар "Сөрөг" дүгнэлт авсан 2 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит:

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудитаар 231.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 187.9 сая төгрөгийн зөрчилд 10 заалт зөвлөмж, 38.5 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага өгч, 5.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудит:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 1,933.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 171.0 сая төгрөгийн зөрчилд 5 заалт зөвлөмж, 1,762.3 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага өглөө. Санхүүгийн аудитаар "Сөрөг" дүгнэлт авсан 1 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудит:

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 1,552.3 сая төгрөгийн зөрчил илэрч, 1,552.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 3 заалт зөвлөмж хүргүүллээ. Аудитаар нийт илрүүлсэн 1,552.3 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 29.7 сая төгрөгөөр бага тул ***"Өөрчлөлтгүй"*** дүгнэлт өглөө.

4.12 ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЗАЛРУУЛГА

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар залруулга хийгдээгүй бөгөөд харьяа байгууллагуудын хувьд 2,473.2 сая төгрөгийн 49 алдаа илэрч, аудитын явцад залруулсан байна.

Хүснэгт №13 ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын залруулсан алдааны нэгтгэл /сая.төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
								Залруулсан		Залруулаагүй	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	ТТЗ	2	901.2	1	5.1	1	896.1	2	901.2	-	-
2	ТШЗ	44	1,507.8	11	582.4	33	925.4	44	1,507.8	-	-
3	ОНӨААН	3	64.2	-	-	3	64.2	3	64.2	-	-
Нийт дүн		**49**	**2,473.2**	**12**	**587.5**	**37**	**1,885.7**	**49**	**2,473.2**	**-**	**-**

4.13 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,005.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 971.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 34.0 сая төгрөгийн зөрчилд 2 заалт зөвлөмж хүргүүлсэн байна. 971.4 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, 2 заалт зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Хүснэгт №12. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт */сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	**Дүн**	**Тоо**	**Дүн**	**Хувь**
Акт					
Албан шаардлага	5	971.4	5	971.4	100%
Зөвлөмж	2	34.0			0%
Нийт дүн	**7**	**1,005.4**	**5**	**971.4**	**71.4%**

4.14 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Тайлант онд 9 сумын 90 төсөвт байгууллага, сан, төсөл хөтөлбөрүүдэд санхүүгийн иж бүрэн хяналт шалгалт хийж, нийт 43,628.2 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоож, орон нутгийн дансанд төвлөрүүлэхээр ажилласан бөгөөд шалгалт хийгдсэн сумдын удирдлага, төсөвт байгууллага, аж ахуй нэгж албан газруудын эрх бүхий албан тушаалтан, ажиллагсдад төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллажээ. Мөн аймгийн төвийн 16 нэгжид дотоод аудитыг хийж, 106,774.4 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоосон. Хуулийн хэрэгжилтийг хангуулах, зөрчил арилгуулахаар 35 нэгжид 567,761.7 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын төлөвлөгөө боловсруулж, 2025 оны жилийн эцсийн байдлаар албаны улсын /ахлах/ байцаагч нарт байгууллагуудыг хариуцуулан өгч, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт нэмж ажил дүгнэх үзүүлэлт болгосон байна. Төрийн 199 байгууллагын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн байдалд 2 удаа шалгалт хийж, ЗДТГ-ын цахим хуудсаар мэдээлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 2025 онд 96.6 хувьтай байна гэж дүгнэжээ.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа Орон нутгийн өмчит 7 хуулийн этгээдүүд 2025 онд 725.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Харьяа ОНӨААН-үүд алдагдалтай ажиллаж байгаад дүн шинжилгээ хийж, санхүүгийн үр ашгийг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.
2. Аймгийн Засаг даргын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх гэх үндэслэлээр төрийн албан хаагчдад дэмжлэг, уралдаан тэмцээний шагнал, урамшуулал, хоол хүнсний материал, бэлэг дурсгалд 1,285.0 сая төгрөг зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн байна.
3. Их засварын зардлаас 50.0 сая төгрөгийг зориулалт бус төсөл арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан, мөн барьцаа хөрөнгийн дансны үлдэгдлээс 217.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
4. Орон нутгийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн хөрөнгө болон сумдад эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй 476.8 сая төгрөгийн зөрчил байна.
5. ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар ОНХС-ийн хөрөнгийг журам зөрчсөн төсөл арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан, мөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд хийгдээгүй, бүрэн дуусаагүй 3.891.2 сая төгрөгийн зөрчил давтагдан гарч, аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг бодитой хэрэгжүүлж, арга зүйгээр хангаж ажиллах шаардлагатай байна.

5.2 ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА-Д

1. Орон нутгийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн зарцуулалт болон сумдад эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах;
2. Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, харьяа байгууллагуудыг арга зүйгээр хангаж ажиллах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТЕЗ-ийн харьяа Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд алдагдалтай ажиллаж байгаад дүн шинжилгээ хийж, санхүүгийн үр ашгийг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.	1	-			1	-						
Аймгийн Засаг даргын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх гэх нэрийн дор төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дэмжлэг, уралдаан тэмцээний шагнал, урамшуулал, хоол хүнсний материал, бэлэг дурсгалд 1,285.0 сая төгрөг зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн байна.	1	1,285.0			1	1,285.0						
Их засварын зардлаас 50.0 сая төгрөгийг зориулалт бус төсөл арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан. Барьцаа хөрөнгийн дансны үлдэгдлээс 217.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.	1	267.3			1	267.3						
Орон нутгийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн хөрөнгө болон сумдад	1	-					1	-				

эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй 476.8 сая төгрөгийн байна.												
ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар ОНХС-ийн хөрөнгийг журам зөрчсөн төсөл арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан, мөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд хийгдээгүй, бүрэн дуусаагүй 3.891.2 сая төгрөгийн зөрчил давтагдан гарч, аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг бодитой хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.	1	-					1	-				
Нийт дүн	**5**	**1,552.3**			**3**	**1,552.3**	**2**	**-**				

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	ТТЗ	Дөрвөлжин сумын Засаг дарга	2	901.22	1	5.08	1	896.15						
	Дүн		**2**	**901.22**	**1**	**5.08**	**1**	**896.15**						
1	ТШЗ	Завхан аймгийн ЗДТГ	1	2.55			1	2.55						
2		Алдархаан сумын ЗДТГ	4	246.98	1	19	3	227.98						
3		Асгат сумын ЗДТГ	2	13.82			2	13.82						
4		Баянтэс сумын ЗДТГ	1	32.43			1	32.43						
5		Баянхайрхан сумын ЗДТГ	2	13.08			2	13.08						
6		Дөрвөлжин сумын ЗДТГ	5	225.47	1	51.08	4	174.39						
7		Идэр сумын ЗДТГ	2	14.38			2	14.38						
8		Отгон сумын ЗДТГ	2	86.25			2	86.25						
9		Сонгино сумын ЗДТГ	3	42.05	1	6	2	36.05						
10		Шилүүстэй сумын ЗДТГ	1	129.8	1	129.8								
11		Улиастай сумын ЗДТГ	2	241.19	2	241.19								

12		Ургамал сумын ЗДТГ	4	116.85			4	116.85							
13		Аймгийн ИТХ	1	20.63			1	20.63							
14		Отгон сумын ИТХ	2	1.21			2	1.21							
15		Улиастай сумын ИТХ	1	74.5			1	74.5							
16		Байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	54.31			1	54.31							
17		Завхан аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл	3	62.74	2	61.24	1	1.5							
18		Тосонцэнгэл сум дахь сум дундын ойн анги	2	32.31	1	0.47	1	31.84							
19		Түдэвтэй суман дахь сум дундын ойн анги	2	13.34	1	3.96	1	9.38							
	Дүн		**41**	**1423.89**	**10**	**512.74**	**31**	**911.15**							
1	ОНТС	Асгат сумын ОНХС	1	69.6	1	69.6									
2		Баянхайрхан сумын ОНХС	1	13.0			1	13.0							
3		Завханмандал сумын ХХС	1	1.3			1	1.3							
	Дүн		**3**	**83.9**	**1**	**69.6**	**2**	**14.3**							
1	ОНӨҮГ	Тосонцэнгэл сумын Мөнхийн алба ерхийн эмнэлэг	3	64.2			3	64.2							
Дүн			**3**	**64.2**	**0**	**0**	**3**	**64.2**							
Нийт дүн			**49**	**2,473.21**	**12**	**587.42**	**37**	**1,885.80**							

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр		Нийт зөрчил		Үүнээс										
					Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хуулийн байгууллагад шилжүүлэх	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Мөнгөн дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1	ТТЗ	Алдархаан сумын Засаг дарга	2	60.1					2	60.1					
2		Асгат сумын Засаг дарга	0	0.0											
3		Баянхайрхан сумын Засаг дарга	1	130.3			1	130.3							
4		Дөрвөлжин сумын Засаг дарга	1	111.0					1	111.0					
5		Завханмандал сумын Засаг дарга	0	0.0											
6		Их-Уул сумын Засаг дарга	0	0.0											

7		Нөмрөг сумын Засаг дарга	1	216.8			1	216.8								
8		Отгон сумын Засаг дарга	2	92.8			1	92.8			1	1				
9		Сонгино сумын Засаг дарга	1	108.9			1	108.9								
10		Тосонцэнгэл сумын засаг дарга	1	380.2			1	380.2								
11		Түдэвтэй сумын Засаг дарга	0	0.0												
12		Улиастай сумын засаг дарга	1	343.1			1	343.1								
13		Ургамал сумын Засаг дарга	0	0.0												
14		Цагаанхайрхан сумын Засаг дарга	1	107.0			1	107.0								
15		Цэцэн-Уул сумын Засаг дарга	1	226.5			1	226.5								
16		Шилүүстэй сумын Засаг дарга	1	42.2			1	42.2								
17		Эрдэнэхайрхан сумын Засаг дарга	1	32.1			1	32.1								
18		Яруу сумын Засаг дарга	1	82.3			1	82.3								
19		Тэлмэн сумын Засаг дарга	0	0.0												
		Дүн	**15.0**	**1,933.3**			**11**	**1,762.2**	**3.0**	**171.1**	**1**	**1**				
1	ТШЗ	Завхан аймгийн ЗДТГ	3	79.6			2	60.6	1	19.0						
2		Алдархаан сумын ЗДТГ	4	32.4	1	2.1	2	12.9	1	17.4						
3		Асгат сумын ЗДТГ	1	2.5			1	2.5								
4		Баянтэс сумын ЗДТГ	5	12.8	1	0.7	3	10.7	1	1.4						
5		Баянхайрхан сумын ЗДТГ	5	248.3	2	1.9	1	2.5	2	243.9						
6		Дөрвөлжин сумын ЗДТГ	5	30.7	2	1.4	3	29.3								
7		Завханмандал сумын ЗДТГ	2	15.8	1	0.7	1	15.1								
8		Идэр сумын ЗДТГ	2	2.8	1	0.8	1	2.0								
9		Их-Уул сумын ЗДТГ	5	21.9			2	5.1	3	16.8						
10		Нөмрөг сумын ЗДТГ	0	-												
11		Отгон сумын ЗДТГ	2	3.1			2	3.1								
12		Сантмаргаз сумын ЗДТГ	2	1.7			2	1.7								
13		Сонгино сумын ЗДТГ	3	13.8			3	13.8								
14		Тосонцэнгэл сумын ЗДТГ	3	53.3					3	53.3						
15		Түдэвтэй сумын ЗДТГ	6	36.0	2	0.8	4	35.2								
16		Тэлмэн сумын ЗДТГ	0	-												
17		Тэс сумын ЗДТГ	3	3.5					3	3.5						
18		Цагаанхайрхан сумын ЗДТГ	5	113.7	1	3.3	4	110.4								

19		Цэцэн-Уул сумын ЗДТГ	3	11.1					3	11.1					
20		Шилүүстэй сумын ЗДТГ	4	8.7	1	0.3	3	8.4							
21		Улиастай сумын ЗДТГ	14	439.4	6	17.9	7	421.5			1	1			
22		Ургамал сумын ЗДТГ	3	4.3	2	1.3	1	3.0							
23		Эрдэнэхайрхан сумын ЗДТГ	1	2.7	1	2.7									
24		Яруу сумын ЗДТГ	10	50.1	3	6.4	5	11.0	1	32.7	1	1			
25		Аймгийн ИТХ	9	752.6	1	2.0	7	636.6	1	114.0					
26		Асгат сумын ИТХ	2	1.0	2	1.0									
27		Баянтэс сумын ИТХ	1	4.0			1	4.0							
28		Баянхайрхан сумын ИТХ	1	1.5			1	1.5							
29		Дөрвөлжин сумын ИТХ	1	0.7	1	0.7									
30		Завхан аймгийн ИТХ	0	-											
31		Их-Уул сумын ИТХ	0	-											
32		Нөмрөг сумын ИТХ	0	-											
33		Сантмаргаз сумын ИТХ	1	1.6					1	1.6					
34		Улиастай сумын ИТХ	4	82.7			4	82.7							
35		Ургамал сумын ИТХ	2	6.1			1	3.5	1	2.6					
36		Цагаанхайрхан сумын ИТХ	1	1.7			1	1.7							
37		Цагаанчулуут сумын ИТХ	0	-											
38		Шилүүстэй сумын ИТХ	1	0.9			1	0.9							
39		Яруу сумын ИТХ	3	16.9	1	0.9	2	16.0							
40		Аймгийн ОНХС	5	1,501.5			5	1,501.5							
41		Алдархаан сумын ОНХС	5	108.1			5	108.1							
42		Асгат сумын ОНХС	4	63.7			4	63.7							
43		Баянхайрхан сумын ОНХС	4	91.5			4	91.5							
44		Дөрвөлжин сумын ОНХС	3	111.0			3	111.0							
45		Завханмандал сумын ОНХС	1	27.5			1	27.5							
46		Отгон сумын ОНХС	4	65.3			4	65.3							
47		Нөмрөг сумын ОНХС	2	216.8			2	216.8							
48		Тосонцэнгэл сумын ОНХС	2	248.2			2	248.2							

49		Тэс сумын ОНХС	2	28.1					2	28.1					
50		Улиастай сумын ОНХС	3	152.6			3	152.6							
51		Ургамал сумын ОНХС	0	-											
52		Цэцэн-Уул сумын ОНХС	2	203.2			1	194.2	1	9.0					
53		Шилүүстэй сумын ОНХС	2	38.5			2	38.5							
54		Эрдэнэхайрхан сумын ОНХС	1	69.5			1	69.5							
55		Яруу сумын ОНХС	1	66.1			1	66.1							
56		Авто замын сан	2	99.8			2	99.8							
57		Асгат сумын ХХС	1	53.1			1	53.1							
58		Алдархаан сумын ХХС	0	-											
59		Баянтэс сумын ХХС	2	51.6			1	15.2	1	36.4					
60		Дөрвөлжин сумын ХХС	0	-											
61		Завханмандал сумын ХХС	1	16.8			1	16.8							
62		Отгон сумын ХХС	1	24.4			1	24.4							
63		Сонгино сумын ХХС	1	100.6			1	100.6							
64		Тосонцэнгэл сумын ХХС	1	84.2			1	84.2							
65		Тэлмэн сумын ХХС	0	-											
66		Тэс сумын ОНХС	0	-											
67		Улиастай сумын ОНХС	0	-											
68		Ургамал сумын ОНХС	0	-											
69		Цэцэн-Уул сумын ХХС	1	23.4			1	23.4							
70		Эрдэнэхайрхан сумын ХХС	2	19.4			2	19.4							
71		Яруу сумын ХХС	1	16.2			1	16.2							
72		Улиастай сумын ХТҮА	0	-											
73		Байгаль орчин, аялал жуулчлалын газар	4	29.3	1	0.6	1	13.5	2	15.2					
74		Завхан аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл	3	10.0	1	0.5			2	9.5					
75		Тосонцэнгэл сум дахь сум дундын ойн анги	0	-											
76		Түдэвтэй суман дахь сум дундын ойн анги	0	-											
		Дүн	**178**	**5,578.3**	**31**	**46.0**	**116**	**4,916.8**	**29**	**615.5**	**2**	**2**			

1	ОНӨҮГ	Завхан аймгийн засаг даргын тамгын газрын дэргэдэх теле камерын хяналтын дэд төв	2	4.8	1	0.1	1	4.7							
2		Тосонцэнгэл сумын Мөнхийн алба өрхийн эмнэлэг	1	149.5					1	149.5					
3		Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв	1	29.9					1	29.9					
4		ОЧИР-ИЛЧ	3	13.5	1	1.7	2	11.8							
5		Тосонцэнгэл сумын хот тохижилтын алба	2	1.3					2	1.3					
6		Тосон очирт хайрхан	1	1.2					1	1.2					
7		Улиастай сумын хот тохижилт үйлчилгээний алба	2	14.3			2	14.3							
8		Эрдэнэ хайрхан хөгжил	7	17.2	3	3.5	1	7.7	3	6.0					
	Дүн		**19**	**231.7**	**5**	**5.3**	**6**	**38.5**	**8**	**187.9**					

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр		Нийт зөрчил		Үүнээс										
					Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хуулийн байгууллагад шилжүүлэх	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Мөнгөн дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил															
1	ТТЗ	Алдархаан сумын Засаг дарга	1	-					1	-					
2		Дөрвөлжин сумын Засаг дарга	1	-					1	-					
3	ОНӨҮГ	Завхан аймгийн засаг даргын тамгын газрын дэргэдэх теле камерын хяналтын дэд төв	1	-					1	-					
4		Завхан аймгийн улиастай сумын хот тохижилт үйлчилгээний алба	1	-					1						
5	ТШЗ	Цагаанчулуут сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	267.4					1	267.4					
6		Яруу сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	720.9					1	720.9					

7		Алдархаан сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	0.00			1								
8		Дөрвөлжин сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	0.00			1								
9		Улиастай сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	0.00			1								
10		Завхан аймгийн Алдархаан сумын Засаг даргын Тамгын газар	1	2955.4					1	2,955.4					
11		Завхан аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл	1	46.9					1	46.9					
Дүн			**11**	**3,990.8**	**0**	**0**	**3**	**0**	**8**	**3,990.8**	**0**	**0**	**0**	**0**	**0**
Нийт дүн			**223**	**11,734.0**	**36**	**51.3**	**136**	**6,717.5**	**48**	**4,965.2**	**3**	**3**	**0**	**0**	**0**

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

2026.04.20

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

2026.04.20

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 20 өдөр Дугаар А/13 Улаанбаатар

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 18.10 дахь хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан"-г нэгдүгээр хавсралтаар, аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн Засаг дарга Г.Өнөрбаярт хүргүүлэхийг ахлах аудитор (Ц.Оюунсувд)-д, нээлттэй аудит сайтад байршуулахыг аудитор (Г.Нармандах)-д даалгасугай.

3. Аудитаар хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга Г.Өнөрбаярт зөвлөсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

Д.БАТ-УНДРАА

8120010025